



## Бурхан бол Миний хувь Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

**Мөн чанар: Бурхан бол Миний хувь**

**Attribute: God Is My Portion**

**Тодорхойлолт:** (Бурханаас өгөгдсөнийг) хуваалцах, эзэмших, шагнал болгох ... Итгэгч бидний хувьд бид Бурханы гэр бүлийн хэсэг байх эрхтэй... Амьд Бурханыг магтан хүндлэгчдийн дунд нэгдэн орж ирэх боломжтой юм.

**Эшлэл(үүд):**

- **Дэд хууль 32:9** ЭЗЭНий хувь нь Өөрийнх нь ард түмэн, Иаков бол Түүний сонгож авсан өв.
- **Дуулал 73:26** Бие махбод хийгээд зүрх минь үгүй болж болох ч, Буран мөнхөд зүрхний минь хад хувь ногдол минь юм.
- **Дуулал 119:57-58** ЭЗЭН миний хувь юм. Би Таны үгийг сахин биелүүлэхээр амласан билээ. Бүхий л зүрхээр Таны ивээлийг би хайсан билээ. Үгийнхээ дагуу надад нигүүлсэнгүй байгаач.
- **Дуулал 142:5** Аяа ЭЗЭН, би Танд хашхирч, хэлэхдээ “Миний хоргодох газар, Амьдын нутагт миний хувь Та юм.
- **Матай 6:33** Гагцхүү эхлээд Бурханы хаанчлал ба зөвт байдлыг хайгтүн. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

*Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9*

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй.

*Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

**Өөрсдийн хүүхдүүдийн төлөө** — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

**Эшлэл(үүд):** Гашуудал 3:24

**Библийн эшлэлээр залбирах:**

ЭЗЭН Та бол (Хүүхдийн нэр)-ий хувь билээ. Тиймээс (Хүүхдийн нэр) Танд найддаг билээ.

**Залбирлын тодорхой хүсэлт:**

**Багш/Ажилчид** (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та \_\_\_\_\_-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Танд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- ЭЗЭН Та бол \_\_\_\_\_-ий хувь билээ. Тиймээс \_\_\_\_\_ Танд найддаг билээ. *Гашуудал 3:24*

**Сургуулийн төлөө залбирах** – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

**Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах** — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

*Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!*